

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/003/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал
Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.15 № 53
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Э.ГЭРЭЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд 4 албан хаагчид 1,998.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон,
2. Орон нутгийн нэмэгдэл цалин бодож олгохдоо 32,507.5 мянган төгрөгийг 20 хувиар илүү тооцож олгосон,
3. Тайлант онд 11,779.2 мянган төгрөгийн аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой өр төлбөр үүсгэн ажилласан,
4. Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй,

612505322

шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож 1,474.9 мянган төгрөг зарцуулсан,

5. Автомашин, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцана", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2.1-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно" гэж заасныг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2025 оны санхүүгийн тайлангийн хугацаанд орон нутгийн төсвөөс 1,267,091.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 30,000.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 206,525.3 мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татаан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзэхээр байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "Суралцагч хот" хөтөлбөрийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталж, нийт 250,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,940,501.30	22,022,021.40
33	АВЛАГА	76,879.90	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	76,879.90	-
35	БАРАА МАТЕРИАЛ	77,863,621.40	22,022,021.40
351	Түүхий эд материал	70,409,821.40	16,902,481.40
35110	Тусгай зориулалттай материал	70,409,821.40	16,902,481.40
354	Хангамжийн материал	7,453,800.00	5,119,540.00
35410	Бичиг хэргийн материал	4,503,000.00	1,840,050.00
35420	Аж ахуйн материал	2,908,700.00	3,237,390.00
35470	Бусад хангамжийн материал	42,100.00	42,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	109,551,354.53	100,453,515.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	109,551,354.53	100,453,515.79
392	Биет хөрөнгө	103,926,354.55	96,278,515.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,792,946.50	3,792,946.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,137,883.68)	(1,327,530.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,650,000.00	162,650,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,650,000.08)	(112,741,666.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,050,680.00	80,153,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,168,513.39)	(46,275,789.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,152,240.00	31,932,754.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,763,114.80)	(21,906,097.81)
393	Биет бус хөрөнгө	5,624,999.98	4,174,999.94
39301	Программ хангамж	8,220,000.00	8,340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,555,000.02)	(5,125,000.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	960,000.00	960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	187,491,855.83	122,475,537.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	(11,779,200.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	(11,779,200.00)
413	Өглөг	-	(11,779,200.00)
4136	Бусад өглөг	-	(11,779,200.00)
41361	Байгууллагад төлөх өглөг	-	(11,779,200.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	170,795,730.16	117,558,611.52
51	Засгийн газрын хувь оролцоо	170,795,730.16	117,558,611.52
512	Хуримтлагдсан үр дүн	168,511,849.76	115,274,731.12
51210	Өмнөх үеийн үр дүн	168,511,849.76	168,511,849.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	(53,237,118.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,283,880.40	2,283,880.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	170,795,730.16	105,779,411.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,023,079,491.00	1,371,088,318.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,025,191.00	73,996,418.24
120	Нийтлэг татварын бус орлого	29,025,191.00	73,996,418.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	8,472,991.00	73,511,714.24

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	20,552,200.00	484,704.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	994,054,300.00	1,297,091,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	994,054,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	994,054,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,267,091,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,267,091,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	990,121,456.22	1,377,275,558.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,121,456.22	1,377,275,558.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	797,166,280.43	1,094,205,815.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,554,481.55	463,895,882.15
210101	Үндсэн цалин	144,388,353.70	364,825,881.97
210102	Нэмэгдэл	83,081,314.05	80,532,129.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,842,000.00	9,114,298.70
210104	Урамшуулал	12,067,500.00	2,855,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	79,175,313.80	6,568,072.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,962,568.15	57,902,568.11
210201	Тэтгэврийн даатгал	29,690,534.29	43,018,703.66
210202	Тэтгэмжийн даатгал	5,029,391.11	1,306,829.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,533,582.20	816,783.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,264.22	437,269.74
210205	Эрүүл мэндийн даатгал	5,327,796.33	12,322,981.46
2104	Хангамж, бараа материалын зардал	23,469,707.91	26,645,020.00
210401	Бичиг хэрэг	9,954,900.00	9,305,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,352,200.00	10,851,704.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,415,507.91	74,866.00
210404	Ном, хэвлэл	1,140,000.00	5,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,607,100.00	1,212,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,423,000.00	4,086,000.00
210604	Урсгал засвар	7,423,000.00	4,086,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,729,900.00	1,745,000.00
210702	Дотоод албан томилолт	2,729,900.00	1,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,796,197.04	9,720,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,038,000.00	9,300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,553,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,825.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,565,372.04	420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,230,425.78	530,211,344.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,807,499.66	467,682,570.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,454,600.00	1,095,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,968,326.12	61,433,274.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,955,175.79	283,069,743.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	86,800,000.00	67,200,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	86,800,000.00	67,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,331,098.00	16,205,000.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,493,098.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,838,000.00	16,205,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	52,824,077.79	199,664,743.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,824,077.79	199,664,743.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,958,034.78	(6,187,240.08)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	47,049,878.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	47,049,878.56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(47,049,878.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,958,034.78	(53,237,118.64)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	994,054,300.00	1,297,091,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	994,054,300.00	1,297,091,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	994,054,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	994,054,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,267,091,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,267,091,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	972,851,600.00	1,268,238,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	972,851,600.00	1,268,238,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	693,313,424.21	872,328,756.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,561,379.50	502,636,669.79
210101	Үндсэн цалин	142,198,542.49	271,099,606.08
210102	Нэмэгдэл	87,712,505.01	179,280,273.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,842,000.00	32,490,298.70
210104	Урамшуулал	12,067,500.00	13,198,419.33
210105	Гэрээт ажлын хөлс	78,740,832.00	6,568,072.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,878,549.76	60,724,378.98
210201	Тэтгэврийн даатгал	29,352,636.41	42,752,314.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,892,251.86	4,356,460.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,446,125.96	2,178,242.76
210204	Ажилгүйдлийн даатгал	914,633.60	2,018,192.76
210205	Эрүүл мэндийн даатгал	6,272,901.93	9,419,168.03
2104	Хангамж, бараа материалын зардал	24,824,857.91	23,167,773.00
210401	Бичиг хэрэг	8,092,450.00	8,466,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,800,000.00	7,525,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,415,507.91	1,619,573.00
210404	Ном, хэвлэл	5,122,000.00	3,522,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,394,900.00	2,034,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,423,000.00	6,083,290.00
210604	Урсгал засвар	7,423,000.00	6,083,290.00

2107	Томилолт, зочны зардал	2,729,900.00	2,545,000.00
210702	Дотоод албан томилолт	2,729,900.00	2,545,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,848,197.04	35,783,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,910,000.00	25,599,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,553,000.00	5,082,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,825.00	200,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,745,372.04	4,352,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	234,047,540.00	241,388,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,292,940.00	233,019,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,754,600.00	8,369,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,538,175.79	395,909,743.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	173,600,000.00	162,400,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	173,600,000.00	162,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,114,098.00	33,845,000.02
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,193,098.00	7,552,000.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,921,000.00	26,293,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	52,824,077.79	199,664,743.21
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,824,077.79	199,664,743.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,202,700.00	28,853,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,202,700.00	28,853,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,202,700.00	28,853,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,202,700.00	28,853,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,202,700.00	28,853,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,202,700.00)	(28,853,400.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,696,125.67	-	-	16,696,125.67
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	168,511,849.76	187,491,855.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,696,125.67	-	-	16,696,125.67
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(53,237,118.64)	(53,237,118.64)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,696,125.67	2,283,880.40	115,274,731.12	134,254,737.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү, дутуу	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,423,994,390.0	1,060,759,256.8	363,235,133.21	74.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,423,994,390.0	1,060,759,256.8	363,235,133.21	74.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,212,167,390.0	868,814,256.8	343,353,133.23	71.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,534,730.0	502,636,669.8	187,898,060.21	72.79
210101	Үндсэн цалин	402,175,230.0	271,099,606.1	131,075,623.92	67.41
210102	Нэмэгдэл	246,317,500.0	179,280,273.7	67,037,226.32	72.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,042,000.0	32,490,298.7	9,551,701.30	77.28
210104	Урамшуулал	-	13,198,419.3	(13,198,419.33)	
210105	Гэрээт ажлын хөлс	-	6,568,072.0	(6,568,072.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,316,790.0	60,724,379.0	25,592,411.02	70.35
210201	Тэтгэврийн даатгал	58,695,490.0	42,752,314.9	15,943,175.09	72.84
210202	Тэтгэмжийн даатгал	6,905,390.0	4,356,460.5	2,548,929.48	63.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,452,630.0	2,178,242.8	1,274,387.24	63.09
210204	Ажилгүйдлийн даатгал	3,452,630.0	2,018,192.8	1,434,437.24	58.45
210205	Эрүүл мэндийн даатгал	13,810,650.0	9,419,168.0	4,391,481.97	68.20
2104	Хангамж, бараа материалын зардал	29,365,870.0	17,473,373.0	11,892,497.00	59.50
210401	Бичиг хэрэг	9,208,370.0	6,467,050.0	2,741,320.00	70.23
210402	Тээвэр, шатахуун	9,100,000.0	7,525,000.0	1,575,000.00	82.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,145,000.0	1,619,573.0	525,427.00	75.50
210404	Ном, хэвлэл	5,662,500.0	242,000.0	5,420,500.00	4.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,250,000.0	1,619,750.0	1,630,250.00	49.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,850,000.0	21,408,190.0	59,441,810.00	26.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,600,000.0	15,324,900.0	39,275,100.00	28.07
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,250,000.0	-	1,250,000.00	0.00
210604	Урсгал засвар	25,000,000.0	6,083,290.0	18,916,710.00	24.33
2107	Томилолт, зочны зардал	7,630,000.0	2,545,000.0	5,085,000.00	33.36
210702	Дотоод албан томилолт	7,630,000.0	2,545,000.0	5,085,000.00	33.36

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,627,000.0	35,783,025.0	9,843,975.00	78.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,300,000.0	25,599,000.0	5,701,000.00	81.79
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,082,000.0	5,082,000.0	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.0	550,000.0	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,000.0	200,025.0	56,975.00	77.83
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	-	44,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,380,000.0	4,352,000.0	4,028,000.00	51.93
210807	Газрын төлбөр	14,000.0	-	14,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271,843,000.0	228,243,620.0	43,599,380.00	83.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	260,343,000.0	219,874,120.0	40,468,880.00	84.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,500,000.0	8,369,500.0	3,130,500.00	72.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	211,827,000.0	191,945,000.0	19,881,999.98	90.61
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	162,400,000.0	162,400,000.0	-	100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	162,400,000.0	162,400,000.0	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,427,000.0	29,545,000.0	19,881,999.98	59.78
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,000,000.0	7,552,000.0	447,999.98	94.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,427,000.0	21,993,000.0	19,434,000.00	53.09
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,267,091,900.0	(1,267,091,900.00)	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,267,091,900.0	(1,267,091,900.00)	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	1,267,091,900.0	(1,267,091,900.00)	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт дансны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,139,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,139,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,839,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,694,400.00
210401	Бичиг хэрэг	1,999,400.00
210404	Ном, хэвлэл	3,280,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	415,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,145,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,145,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,860,600.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	6,860,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47,760.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,998.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 44,286.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,474.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Үр дүнгийн урамшуулал олгохдоо 1,998.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар илүү тооцож олгосон, тайлант онд аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой өр төлбөр үүсгэн ажилласан нийт 44,286.7 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Автомашин, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Машин, тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтөлж, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаж байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож 1,474.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", ам тээврийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй байна.

Зөвлөмж:

Автомашинны шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулан, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

Дээрх Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		